

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**  
**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**

**ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

**Нэг. ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар /Төрийн өмчит үйлдвэрийн газар/-ын 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын Төсвийн тухай, Дипломат албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн акт, дүрэм журмын мөрдөлт хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд зорилго чиглэгдлээ.

Шалгалтыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д. Гэрэл, Н.Батбаатар, улсын байцаагч С.Баттөр, Б.Гантулга нар хийж гүйцэтгэлээ.

ДБҮЭГ-ын захирал, ерөнхий санхүүч нь 2016 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журам, аргачлалыг баримтлан санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу хуулийн хугацаанд нь гаргаж, хөндлөнгийн аудитын “Бодит бүртгэл” аудит ХХК-иас “Зөрчилгүй” гэсэн санал дүгнэлттэйгээр холбогдох газарт тушаажээ.

**Байгууллагын тухай.**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 100 тоот тогтоолыг үндэслэн гарсан Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 501 тоот тогтоолын 7-д “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болгон зохион байгуулжээ.

Энэхүү тогтоолын 11-д Засгийн газрын агентлаг болон төсвийн зарим байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын дарга, Сангийн сайд, нийслэлийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай гээд 8 төрлийн үүрэг даалгавар өгөгджээ. Энэ тогтоолын 11-ийн в-д заасан Иргэний хуульд заасны дагуу “Татан буулгах комисс”-ыг байгуулж өөрчлөн байгуулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна.

Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар нь 2016 оны эхнээс Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын /статустайгаар/ үйл ажиллагаагаа явуулж, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 28 тоот тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг баталжээ.

Улмаар Сангийн сайдын 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 189 тоот тушаалаар “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар, захиргааны албан тушаалын жагсаалтыг гуравдугаар, орон тооны нормативыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталж хэрэгжүүлсэн байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 83 тоот тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, дүрэм, захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсан байна.

Шинэчилсэн бүтцээр Захиргааны хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, Үйлчилгээ ашиглалтын хэлтэс гэсэн 3 хэлтэс, Авто бааз, Харуул хамгаалалтын алба, Зоог үйлчилгээний алба, Засвар үйлчилгээний алба гэсэн 4 албатай, 138 хүний орон тоотойгоор баталжээ.

Монгол Улс Венийн конвенцид нэгдэн орсноор уг гэрээнд заасны дагуу хүлээн авагч улс Дипломат төлөөлөгчийн газрыг, байр орон сууцаар хангах, тэдний ая тухтай оршин сууж, үйл ажиллагаагаа эрхлэх бүхий л нөхцлийг хангах үүрэг хүлээсний дагуу уг чиг үүргийг гүйцэтгүүлэхийн тулд Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрыг байгуулдаг байна. Гадаад харилцааны яамны үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын эх үндэс 1951 онд Монгол Улсын гадаад харилцаа өргөжин, Улаанбаатар хотод суугаа гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газруудын тоо өссөн тул тухайн үеийн Гадаад Явдлын Яамны сайдын 45 тоот тушаалаар “Элчингүүдэд үйлчлэх тасаг” нэртэйгээр анх байгуулагдаж, 2016 онд 65 жилийн ойгоо тэмдэглэсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 46 тоот тогтоолоор /2012-2015 онд/ “Дипломат

байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” УТҮГ /орон тоо-170/ ажилтантай ажиллаж байжээ.

Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 501 тоот тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулж ажиллуулсан байна.

**Хоёр. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:**

**2.1 Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-ын 2016 оны зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийн талаар.**

*/ мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлтүүд	2015 оны гүйцэтгэл	2016 оны		Зөрүү / +, - /	хувь
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
	Ашиглалт, үйлчилгээний зардлын орлого	4,179,277.0	4,356,265.0	2,389,838.0	198,657.0	105.0
	ЭСЯ-ын түрээсийн орлого			2,165,084.0		
	Зоогийн үйлчилгээний орлого	183,163.0	22,426.0	155,840.0	33,414.0	127.0
	Автобаазын орлого		148,000.0	167,454.0	19,454.0	113.0
	Бусад түрээсийн орлого		148,688.0	402,400.0	253,712.0	171.0
	Бусад үйлчилгээний орлого	18,138.0	8,160.0	255,886.0	247,726.0	3036.0
	Тусламж санхүүжилтийн орлого	3,772,937.0	-	-	-	
1	<b>Нийт орлого</b>	<b>8,153,515.0</b>	<b>4,783,539.0</b>	<b>5,536,502.0</b>	<b>752,963.0</b>	<b>116.0</b>
2	<b>Нийт зардал</b>	<b>9,090,063.0</b>	<b>4,771,848.0</b>	<b>5,504,840.0</b>	<b>732,991.0</b>	<b>115.0</b>
3	Татварын өмнөх ашиг	/ 936,547.0 /	11,690.0	31,662.0	19,972.0	171.0
4	Цэвэр ашиг /алдагдал/	-	10,521.0	30,873.0	20,352.0	193.0
5	Орлогын албан татвар		1,169.0	789.0	/ 380.0 /	-33.0
6	Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал	1,11	1.00	0.99	0.01	
7	Төрийн өмчийн ногдол ашиг	-	2,104.0	6,175.0	4,070.0	193.0
8	Нийт ажиллагсадын тоо	175	125	153	28	122.0
9	Нийт цалингийн сан	1,523,622.0	980,346.0	1,292,516.0	312.0	132.0
10	Нийт авлага	720,172.0	576,137.0	916,017.0	339,880.0	159.0
11	Нийт өглөг	33,955.0	16,978.0	399,188.0	382,211.0	2362.1

Тус байгууллага нь 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон өөрчлөгдсөн байна. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг анх удаа гарган 2016 оны 5 дугаар сард Сангийн сайдын тушаалаар батлуулсан. Төсвийн жилийн эхнээс эрх бүхий байгууллагаар баталгаажсан төлөвлөгөөгүй ажилласан байна.

“ДБҮЭГ” ТӨҮГ нь 2016 онд 4,783.5 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэлээр 5,536.5 сая төгрөг болж 16.0 хувиар буюу 753.0 сая

төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч, орлогын өсөлттэй дүйцэхүйц хэмжээгээр зардал өссөн байна.

Цэвэр ашиг гүйцэтгэлээр 30.9 сая төгрөг болж, төлөвлөсөн хэмжээнээс 20.4 сая төгрөгөөр 2,9 дахин давуулан биелүүлжээ.

Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 1 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0,99 төгрөг болж, 0.01 мөнгөөр буурсан нь нэгжийн өртөг буурсан үзүүлэлт харагдаж байна. Төрийн өмчийн ногдол ашигт 6.2 сая төгрөг төлж, төлөвлөгөөг 193.0 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын өсөлтийн гол шалтгаан нь АНУ болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрчлөлт орж, түрээсийн төлбөрийн тарифыг нэмэгдүүлсэн, байгаль, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан ЭСЯ-уудын хэрэглээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан, орлогын хэмжээ дагаж өссөн байна.

Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болж, үйлчилгээний цар хүрээ өргөжин бусад төрлийн орлогууд нэмэгджээ.

Мөн валютын ханшийн зөрүүнээс 192,044.0 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого орсныг үйл ажиллагааны бус орлогоор тооцож бүртгэлд тусгажээ.

## 2.2. ДБҮЭГ-ийн 2016 оны зардлын гүйцэтгэлийн талаар

Төрийн байгууллага /эдийн засгийн ангилал	Зорилтот түвшин	НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ	ХЭТРЭЛТ ХЭМНЭЛТ	/мян.төг/
				ӨСӨЛТ БУУРАЛТ %-иар
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,938,457.0	4,405,240.0	471,463.0	12
Цалин хөлс НДШ	980,346.0	1,353,554.0	373,208.0	38
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,776,051.0	1,810,210.0	34,160.0	2
Хангамж, бараа материалын зардал	207,920.0	259,579.0	51,659.0	25
Бичиг хэрэг	8,397.0	18,222.0	9,825.0	117
Тээвэр шатахуун	160,000.0	161,038.0	1,038.0	1
Шуудан холбоо	7,929.0	12,009.0	4,081.0	51
Ном хэвлэл авах	975.0	1,432.0	457.0	47
Хортон мэрэгч устгал	345.0	449.0	104.0	30
Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	30,274.0	66,428.0	36,154.0	119
Нормативт зардал	90,707.0	232,742.0	142,036.0	157
Хүнсний материалын зардал	86,295.0	226,048.0	139,753.0	162
ХАБЭА-ийн зардал	4,412.0	6,694.0	2,282.0	52
Эд хогшил, урсгал засварын зардал	223,355.0	336,024.0	112,669.0	50
Багаж техник хэрэгсэл	16,754.0	-	(16,754.0)	-100
Сэлбэг хэрэгсэл	87,861.0	80,887.0	(6,974.0)	-8
Барилгын урсгал засвар	118,740.0	255,137.0	136,397.0	115
Томилолт, зочны зардал	24,872.0	41,765.0	16,893.0	68
Гадаад томилолт	10,000.0	34,329.0	24,329.0	243
Дотоод томилолт	4,872.0	3,335.0	(1,537.0)	-32

Зочин төлөөлөгч хүлээн авах	10,000.0	4,100.0	(5,900.0)	-59
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	165,641.0	103,810.0	(61,830.0)	-37
Ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000.0	2,533.0	533.0	27
Аудитын зардал	4,800.0	11,600.0	6,800.0	142
Нотариат баталгаажуулалтын зардал		352.0	352.0	
Тендерийн материалын зардал		500.0	500.0	
Шүүхийн зардал		9,020.0	9,020.0	
Тээврийн хэрэгслийн даатгал	30,000.0	47,799.0	17,799.0	59
Тээврийн хэрэгслийн татвар	4,500.0	4,446.0	(55.0)	-1
Үл хөдлөх хөрөнгийн татвар	117,591.0	-	(117,591.0)	-100
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,200.0	600.0	(601.0)	-50
Мэдээлэл технологийн зардал	4,000.0	4,620.0	620.0	16
Газрын төлбөр	1,050.0	19,899.0	18,849.0	1795
Банк санхүүгийн үйлчилгээний хураамж	500.0	292.0	(208.0)	-42
Бараа үйлчилгээний бусад зардал	4,680.0	2,150.0	(2,530.0)	-54
ТӨХ Урсгал шилжүүлэг / 20 хувь /	437,314.0	197,515.0	(239,798.0)	-55
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	9,500.0	22,924.0	13,424.0	141
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, дэмжлэг	18,073.0	22,273.0	4,200.0	23
Бүтцийн өөрчлөлтөөр халагдсны тэтгэмж	-	24,844.0	24,844.0	
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>833,391.0</b>	<b>1,099,599.0</b>	<b>266,208.0</b>	<b>32</b>
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	8,703.0	8,703.0	
Элэгдлийн зардал	833,391.0	1,090,896.0	257,505.0	31
<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>11,690.0</b>	<b>31,663.0</b>	<b>19,972.0</b>	<b>171</b>
Орлогын татварын зардал	1,169.0	789.0		0
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>10,521.0</b>	<b>30,873.0</b>	<b>19,972.0</b>	<b>190</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,771,848.0</b>	<b>5,504,840.0</b>	<b>737,671.0</b>	<b>15</b>

Зардал 4,771.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч, гүйцэтгэлээр 5,504.8 сая төгрөг болж 733.0 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар хэтэрчээ.

Тухайн төсвийн жилд төлөвлөгдөөгүй олон арга хэмжээ зохион байгуулагдаж нэмэгдэл зардал гарах шаардлага гарч байсан боловч, тооцоо судалгаагүй хандаж, батлагдсан зардлыг хэтрүүлсэн, төлөвлөгөөгөө баримталж, холбогдох хууль журмыг мөрдөлгүй, зардал гаргасан, санхүүгийн сахилга, зардлын менежмент хангалтгүй байснаас зардлыг хэмнэж хямдруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарч, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хэрэв хууль тогтоомжийг баримтлан, сахилга хариуцлагатай, зөв менежменттэй ажилласан бол үүнээс ч илүү ашигтай ажиллах нөхцөл бололцоотой гэж дүгнэж байна. Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 1 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0,99 төгрөг болж, 0,01 мөнгөөр буурсан нь нэгжийн өртөг буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Төрийн өмчийн ногдол ашигт 6.2 сая төгрөг төлж, төлөвлөгөөг 193.0 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Батлагдсан орон тооны нормативыг баримтлахгүй ажиллаж 28 хүнээр нэмэгдүүлэн ажиллаж, цалингийн санг 312.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил илэрч байна.

Нийт 30 нэрийн зардлаас 10 төрлийн зардлыг 6.7-117.6 сая төгрөгөөр хэмнэж, 20 нэрийн зардлыг 1.0-373.2 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулжээ. Энэ байдлаас үзэхэд дээрхи шалтгаанаас гадна төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байгааг анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

Төлөвлөгөө боловсруулахдаа өмнөх онуудын зардлын гүйцэтгэл, валютын ханш, үйлчилгээнд мөрдөж буй үнэ тариф, үнэлгээ зах зээлийн чиг хандлагыг харгалзан, өөрсдийн суурь судалгаанд тулгуурлан бодитой төлөвлөж, эрх бүхий байгууллагуудад өөрсдийн төслийг оновчтой тайлбарлан хамгаалж баталгаажуулж ажиллах шаардлагатай байна.

Нийт зардлаас хэтэрсэн дүнгийн 373,2 сая төгрөг нь цалингийн сангийн хэтрэлт бөгөөд энэ нь оны эхний 6 сарын байдлаар 178 орон тоотой ажилласан, 7-9 сард эхний батлагдсан төлөвлөгөөний дагуу 125 орон тоотой, 10 дугаар сараас дахин орсон бүтцийн өөрчлөлтийн дагуу 138 орон тоогоор тус тус цалинжуулсан байна. Энэхүү цалингийн сангийн зөрүүг бусад хэмнэгдсэн зардлаас шилжүүлэн зарцуулсан гэж тайлбарлаж байлаа.

Нийт төлөвлөсөн зардлаас хүнсний материалын зардал 139,8 сая төгрөгөөр хэтэрсэн нь хурал, хүлээн авалтуудын тоо, давтамж ихэссэн болон нийт ГХЯ, ДБҮЭГ-ийн ажилтан албан хаагчдын орон тооны өөрчлөлттэй холбогдон өдрийн хоолны материалын зардал өссөн зэргээс шалтгаалж байгаа боловч, зоогийн үйлчилгээний орлого 33.2 сая төгрөгөөр нэмэгджээ.

Барилгын урсгал засварын зардал 136.4 сая төгрөгөөр хэтэрсэн нь ЭСЯ-уудын барилга байгууламж, шугам сүлжээнд цаг уурын байдлаас шалтгаалж, гэмтэл гарч гэнэтийн засварын ажлуудыг хийсэн, АСЕМ-ийн дээд хэмжээний чуулга, уулзалтын зарим арга хэмжээнүүд ГХЯ-ны байранд болохоор төлөвлөгдсөнтэй холбоотой урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн, мөн ГХЯ-ны албан хаагчдын хүүхдийн цэцэрлэгийг шинээр ашиглалтанд оруулсан, ДБҮЭГ нь цэцэрлэг байрлаж байсан байрнаас БНСУ-ын ЭСЯ байрлаж байсан байранд шилжиж байршуулахдаа засвар хийсэн зэргээс шалтгаалжээ.

## Гурав. Авлага, өглөгийн талаар.

### 3.1 Авлагын талаар:

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Дансны авлага ТӨҮГ	16,981.9	4,035,963.5	3,828,732.9	224,212.6
Татвар, НДШ-ийн	1,374.5	45,164.7	3,612.2	42,926.9
Бусад авлага	701,690.1	5,385,304.1	5,438,116.5	648,877.6
Хувь хүмүүсээс авах	125.2	122,214.8	122,340.0	0,00
<b>Авлагын нийт дүн</b>	<b>720,171.7</b>	<b>9,588,647.1</b>	<b>9,392,801.6</b>	<b>916,017.1</b>

Тайлант оны эхэнд 720.2 сая төгрөгийн авлагатай байсан бол төсвийн жилийн дундуур 9,588.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 9,392.8 сая төгрөгөөр хасагдаж, 195.8 сая төгрөгөөр буюу байна 27.2 хувиар өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

БНСУ-ын ЭСЯ-наас 52.0 сая төгрөг, АНУ-ын ЭСЯ-наас 34.0 сая төгрөг, бусад ЭСЯ-даас 28.0 сая төгрөгийн авлагыг оны төгсгөлөөр нэхэмжилсэн он дамжин 2017 оны 1 дүгээр сард барагдсан байна.

Дипломат-95 байрны түрээслэгчдийн үлдэгдэл төлбөр болон, ашиглагчдаас авах төлбөр нийтдээ 457.1 сая төгрөгийн авлагатай байна. Тус газар шүүх, хууль хяналтын байгууллагатай хамтран барагдуулах арга хэмжээ авч эхэлсэн байна.

Мөн худалдан авалт, үйлчилгээ үзүүлсний авлага 224.2 сая төгрөг байна. Үүний 112.3 сая төгрөгийг Гадаад харилцааны яаманд үйлчилгээ үзүүлсний авлага эзэлж байна. /Унааны төлбөр болон засвар үйлчилгээ хийсэн төлбөр/

### 3.2 Өглөгийн талаар:

/мян.төг/

Үзүүлэлт	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Ажиллагсадтай холбоотой өглөг	4,062.5	137,326.8	140,854.3	0.5
Бусад өглөг	29,892.4	1,233,826.6	865,066.4	398.7
Байгууллагад төлөх	28,067.8	1,230,518.5	860,450.9	398.1
Хувь хүмүүст төлөх	1,824.6	3,308.1	4,615.5	0.5
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>33,954.9</b>	<b>1,371,153.5</b>	<b>1,005,920.7</b>	<b>399.2</b>

Оны эхэнд 33.9 сая төгрөгийн өглөгтэй байсан бол жилийн дундуур 1,371.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,005.9 сая төгрөгөөр буурч, 399.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эхнээс бараг 10 дахин өссөн үзүүлэлтэй гарсан шалтгаан нь АСЕМ-ийн үеэр орж ирсэн тавилгыг худалдсаны орлого 304.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх өглөгөөр тусгаж харуулснаас өглөг нэмэгдэхэд гол нөлөөлөл үзүүлсэн бөгөөд мөн НҮБ-ын засварын ажлын урьдчилгаанд олгох 86.1

сая төгрөг, бусад худалдан авсан бараа, материалын үнэ төлөгдөөгүй 8.5 сая төгрөг зэрэг эзэлж байна.

### **3.3. Худалдан авах ажиллагааны талаар:**

Тус байгууллага нь 2016 оны төсвийн жилд худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгаснаар өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 222.8 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөж батлуулжээ. Үүнд: Шатахуун 68.1 сая төгрөгөөр /НТШ/, сэлбэг хэрэгсэл 67.3 сая төгрөгөөр /НТШ/, хүнсний материал 60.0 сая төгрөгөөр /НТШ/-ийн аргаар сонгон шалгаруулалт хийхээр, харин аж ахуйн болон цэвэрлэгээний материал 22.2 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 5.2 сая төгрөгөөр /ХА/-аргаар тус тус худалдан авахаар төлөвлөж хэрэгжүүлжээ.

ДБҮЭГ-ын захирлын 2016 оны А/19 тоот тушаалаар томилогдсон Үнэлгээний хороо нь өөрийн Зоогийн газарт 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүнсний материал” нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2016 оны 5 дугаар сарын 02-ны өдөр зарлажээ.

Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичгийн загварыг ашиглан, Хүнс хөдөө аж ахуйн сайдын тушаалаар баталсан жагсаалтаас дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сонгох чиглэлийг баримтлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан ажиллажээ.

Тухайлбал: 60.0 сая төгрөгийн худалдан авалтын багц нь дотроо дараах 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүн багтаж байна. Үүнд: мах 30.0 сая, гурил 2.4 сая, сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ 3.4 сая, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн 1.0 сая, нөөшилсөн бүтээгдэхүүн нийлүүлэх 1.5 сая, төмс, хүнсний ногоо 2.7, нарийн ногоо нийлүүлэх 3.4, бусад нэр төрлийн хүнсний материал 15.5 сая төгрөгийн гэх мэтээр багцалжээ. Нийт 7 компани оролцож Могул катеринг ХХК шалгарсан байна.

### **3.4. Ази-Европын Дээд түвшний уулзалт /АСЕМ/-д зориулж**

#### **БНХАУ-аас үзүүлсэн буцалтгүй тусламжийн талаар**

БНХАУ-аас 2016 онд буцалтгүй тусламжийн хүрээнд зочид буудлын люкс өрөөний 232, ерөнхийлөгчийн өрөөний 30, стандарт өрөөний 316, нийт 578 иж бүрдэл, мөн хуралдаанд ашиглах /АСЕМ ВЕЛЛА, Шангре-Ла зочид буудлуудад хуралдаан зохион байгуулах/ зориулалттай 5,572 ширхэг албан өрөөний тавилга



эд хогшил, 8,980 ширхэг орчуулгын тоног төхөөрөмж нийлүүлсэнийг АСЕМ-ийн Бэлтгэл ажлын алба /Гадаад харилцааны яам/ хүлээн авсан байна.

Буцалтгүй тусламжийн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар АСЕМ-ийн 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Үндэсний зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар БНХАУ-аас авах тусламжийн тавилга тоног төхөөрөмжийг терминалаас тараагдах үйл ажиллагааг яамдууд өөрсдөө зохион байгуулалтад оролцохыг даалгавар болгосоны дагуу хуваарилалт хийгдэх.

- Үндэсний зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны шийдвэрээр БНХАУ-аас тусламжаар ирэх тавилга тоног төхөөрөмжийг зочид буудлуудад үнийн дүнгээс 50 хувиар багасган, 30 хувийг бэлнээр төлж, үлдэгдэл 20 хувийг 2016 онд багтаан төлөх зарчмаар ажиллахыг Ерөнхийлөгчийн аюулгүй байдал гадаад бодлогын зөвлөх А.Баттөрд үүрэг болгосон байна.

- Мөн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 26 дугаар хуралдаанаар АСЕМ-ийн хуралдаанаар ашигласан буцалтгүй тусламжийн хүрээнд үзүүлсэн тавилга эд хогшил тоног төхөөрөмжүүдийн бүртгэлийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газарт хариуцуулжээ.

- Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Эд хогшил, тоног төхөөрөмж хүлээх авах, бүртгэх, ашиглалтыг тодруулах” А/180 тоот тушаалаар БНХАУ-аас тусламжийн хүрээнд үзүүлсэн тавилга, техник тоног төхөөрөмжийг бүртгэн хураан авч, цаашид яамны үйл ажиллагаанд ашиглаж болох, ашиглагдахгүй илүүдэл хэсгийг тодорхойлон гаргах, зарж борлуулан улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-ын дарга О.Заяамандахад даалгажээ.

ГХЯ-ны ТНБД-ын А/180 тоот тушаалын дагуу ДБҮЭГ-ын даргын 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/65 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулсан байна.

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд АСЕМ-ийн хуралдаан дууссаны дараа Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар хуралдаанд тараагдсан тавилга эд хогшлыг бүртгэн авч, аж ахуйн нэгж компаниудын агуулах болон өөрийн эзэмшлийн Дипломат корпус дахь гараашид зөөн шилжүүлсэн байна.

#### **3.4.1 Зочид бүүдлын зориулалттай тавилгын зарцуулалт :**

Зочид буудлын нийт 578 өрөөний 1,405,310.0 мянган төгрөгийн иж бүрэн тавилгаас 475 өрөөний 1,171,423.5 мянган төгрөгийн тавилгыг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагуудад худалдан, 103 өрөөний 233,886.5 мянган төгрөгийн тавилгыг төрийн 14 байгууллагад үнэ төлбөргүйгээр өгсөн байна.

ТӨБЗГ-ын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 319 дүгээр тогтоолоор дээрх төрийн 14 байгууллагад нийлүүлсэн зочид буудлын иж бүрэн тавилгыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг холбогдох байгууллагуудад даалгасан байна.

#### **3.4.2 Албан өрөөний зориулалттай тавилга, эд хогшлын зарцуулалт:**

Буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн 5,572 ширхэг бүхий 703,539.0 мянган төгрөгийн албан өрөөний зориулалттай тавилга эд хогшлоос төрийн 26 байгууллагад үнэ төлбөргүйгээр өгч, 102,237.0 мянган төгрөгийн тавилгыг хувь хүмүүс, аж ахуйн нэгжид худалдан борлуулсан байна.

ТӨБЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 75 тоот тогтоолоор 87,807.0 мянган төгрөгийн, 2017 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 76 тоот тогтоолоор 5 яаманд 295,069 мянган төгрөгийн, мөн 77 тоот тогтоолоор 5 байгууллагад 32,482.0 мянган төгрөгийн, мөн 78 тоот тогтоолоор 29,036.0 төгрөгийн, 2017 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 121 тоот тогтоолоор 3 байгууллагад 30,096.0 мянган төгрөгийн, мөн 122 тоот тогтоолоор 36,180.0 мянган төгрөгийн, мөн 123 тоот тогтоолоор төрийн 28,287.0 мянган төгрөгийн, 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 318 тоот тогтоолоор 60,165.0 мянган төгрөгийн, нийт 34 төрийн байгууллагад 599,122.0 мянган төгрөгийн албан тасалгааны тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг тус тус зөвшөөрсөн байна.

ТӨБЗГ-ын 2017 оны 318 тоот тогтоолын 3-д 670 иж бүрдэл бүхий 102,237.0 мянган төгрөгийн тавилгыг худалдан борлуулсаны орлогыг 2017 онд багтаан улсын төсвийн өмч хувьчлалын орлогын дансанд төвлөрүүлэхийг даалгасан байна.

ТӨБЗГ-ын 2017 оны 318 тоот тогтоолоор ашиглах боломжгүй албан тасалгааны зориулалттай 3 төрлийн 2,180.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг актлаж устгах шийдвэр гаргажээ.

ТӨБЗГ-ын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 317 тоот тогтоолын 1.1-д: Буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн 1,171,423.5 мянган төгрөгийн үнэ бүхий

зочид буудлын тавилгыг худалдан авсан иргэн, хуулийн этгээдийн төлөгдөөгүй 699,026.2 мянган төгрөгийн төлбөрийг 2017 оны 3 дугаар улиралд багтаан төлүүлэх, 1.3-д: энэхүү орлогоос хөрөнгө тээвэрлэх, хуваарилахтай холбогдон гарсан нийт 116,560.2 мянган төгрөгийн зардлыг суутган тооцож, үлдэх 582,466.0 мянган төгрөгийг өмч хувьчлалын орлогын дансанд 2017 онд багтаан төвлөрүүлэхийг ДБҮЭГ-т даалгасан байна.

Буцалтгүй тусламжийн тавилгыг худалдан борлуулсан тооцоог хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

	Нэр төрөл	Худалдсан тоо.ш	Төлбөл зохих	2016 онд төлсөн	2016.12.31 үлдэгдэл	2017 онд төлсөн	Нийт төлөлт	2017.10.30-ний үлдэгдэл
1	Зочид буудлын тавилга дүн	475	1,171,423.5	368,668.0	802,755.5	281,315.5	649,983.5	521,440.0
	Зочид буудлууд	372	889,817.0	217,302.5	672,514.5	198,440.5	415,743.0	474,074.0
	Хувь хүмүүс	103	281,606.5	151,365.5	130,241.0	82,875.0	234,240.5	47,366.0
2	Албан тасалгааны тавилга дүн	785	102,237.0	0.0	102,237.0	34,473.5	34,473.5	67,763.5
	Бүгд дүн		1,273,660.5	368,668.0	904,992.5	315,789.0	684,457.0	589,203.5

ДБҮЭГ нь 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдөр тавилга худалдсаны орлогоос улсын төсвийн өмч хувьчлалын орлогын дансанд 472,397.3 мянган төгрөгийг шилжүүлжээ. Тус газар нь тавилга худалдсаны орлогыг дансанд өглөгөөр бүртгэж, харин төлөгдөөгүй үлдэгдэлийг авлагаар бүртгээгүй байна.

Зочид буудлын 1,171.4 сая төгрөгийн тавилгыг 2016 онд болсон АСЕМ-ын хуралдааны хугацаанд болон дууссаны дараа худалдан борлуулж дууссан атал бүтэн нэг жил гаруйн хугацаанд төлбөрийн 50 гаруйхан хувийг барагдуулж төрийн өмчийг үнэгүйдүүлж, төрийн өмчийн эд хөрөнгийг зохицуулж бодлогыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага ч хугацаа алдаж шийдвэр гаргасан байна. Дээрх хөрөнгүүдийг үнэлэх, байгууллага, хувь хүмүүст хуваарилж, шилжүүлэх, худалдан борлуулахдаа ямар эрх зүйн шийдвэрийг үндэслэсэн нь тодорхой бус байна.

АСЕМ-ын тавилга, эд хогшил худалдан борлуулахтай холбогдсон зардлыг харуулбал:

/мянган төгрөг/

Д/д	Зардлын төрөл	2016 он	2017 он	НИЙТ
1	Агуулахын түрээс	64,167.0	31,000.0	95,167.0
2	Ачигч тээврийн зардал	1,866.6	3,684.7	5,551.4
3	Шатахууны зардал	-	100,0	100.0
4	Гэрээт нярвын цалин хөлс, НДШ / ажил олгогчоос 11 хувь /, / 2016.08-2017.11 дуустал /	6,425.8	9,449,9	15,875.7

5	Нэмэлт зардал / тээвэр /		300.0	300,0
	<b>БҮГД ДҮН</b>	<b>72,459.5</b>	<b>44,534.5</b>	<b>116,993.1</b>

### **3.4.3 Орчуулгын тоног төхөөрөмжийн талаар**

Буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн 5,441,550.5 мянган төгрөгийн Орчуулгын тоног төхөөрөмжөөс 7,533 ширхэг буюу 4,746.2 сая төгрөгийн төхөөрөмжийг “Нью терравокс” ХХК-д түрээсийн гэрээгээр, Гадаад харилцааны яаманд 1,1150 ширхэг буюу 424.8 сая төгрөгийн, Авилгатай тэмцэх газарт 270.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг өгсөн байна.

“Нью терравокс” ХХК-д 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 2019 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хүртэл 3 жилийн хугацаатай түрээсийн гэрээгээр өгсөн байна. “Тоног төхөөрөмж түрээслэх түрээслүүлэх” гэрээг /гэрээ дугааргүй/ 2019 оны 7 дугаар сарын 19-ний өдөр байгуулж, ДБҮЭГ-ын дарга О.Заяамандах, түрээслэгч компаний ерөнхий захирал Г.Түмэн-Ерөөлт нар байгуулж, ГХЯ-ны ТНБД, АСЕМ-ийн ажлын албаны дарга Д.Ганхуяг баталж гарын үсэг зурцгаасан байна.

Дээрх гэрээгээр түрээслэгч түрээсийн төлбөр төлөхгүйгээр түрээслэгч талаас зохион байгуулах хурал семинар, арга хэмжээнүүдэд өөрийн зардлаар тээвэрлэн, угсарч суурилуулан, мэргэжилтнээр ажиллагааг хариуцуулан ажиллаж үйлчлэхээр талууд тохирчээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төрийн өмчид эд хөрөнгийг дараах хэлбэрээр олж авна”, 6.1.4-т “Хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө” гэсний дагуу буцалтгүй тусламжаар ирсэн бүх хөрөнгө төрийн өмчид хамаарч байхад дээрх хөрөнгийг хариуцсан нярав нь санхүүгийн анхан шатны баримтыг хөтлөөгүй, байгууллага, хувь хүмүүст хөрөнгийг худалдах, шилжүүлэхдээ өөрийн хувийн тооцоо гар бичмэлээр үйлдэж /зарим нэг баримт нь ойлгомжгүй гаргацгүй, ихэнх баримт нь хүлээн авсан, өгсөн гарын үсэггүй, огноогүй/ хийсэн байгаа нь бүртгэл тооцоог хянаж шалгахад хүндрэлтэй байлаа.

Мөн ГХЯам болон Авилгатай тэмцэх газарт өгсөн тоног төхөөрөмжийн талаар албан ёсны шийдвэр ч байхгүй байна.

БНХАУ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн 2,108,8 сая төгрөгийн үнэ бүхий зочид буудлын болон албан өрөөний тавилга эд хогшил, 5,441,6 сая төгрөгийн орчуулгын тоног төхөөрөмж, нийтдээ 7,550.3 сая төгрөгийн хөрөнгийг

хэрхэн үнэлэх болон хуваарилах, худалдах, түрээслэх талаар ТӨБЗГ-ын шийдвэр гараагүй байхад зарцуулсан байна.

**Дөрөв. Үндсэн хөрөнгө болон бараа материалын талаар:**

**4.1. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР.**

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан		Оны эцсийн үлдэгдэл
			шинээр авсан	балансаар шилжүүлсэн	акталсан	
1	Барилга, байгууламж	23,518,167.8		-	-	23,518,167.9
2	Тээврийн хэрэгсэл	3,062,608.2		24,859.5		3,037,748.7
3	Машин, тоног төхөөрөмж	546,986.7			92,692.3	454,294.4
4	Тавилга эд хогшил	509,475.7			20,632.0	488,843.7
5	Програм хангамж	892.3	2,310.0			3,202.3
6	Биет бус хөрөнгө	51,595.0				51,595.0
Дүн		27,689,725.9	2,310.0	24,859.5	113,324.4	27,553,852.0

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгө оны эхэнд 27,689,725.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 2,310.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол жилийн эцэст 24,859.5 мянган төгрөгийн Соната-6 маркын 01-05 УНЗ улсын дугаартай автомашиныг Монгол улсаас Оросын холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын газарт балансаас балансад шилжүүлсэн, машин тоног төхөөрөмж 92,692.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 20,632.0 мянган төгрөгөөр нийт 113,324.4 мянган төгрөгөөр хасагдаж, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2170 нэр төрлийн 27,553,852.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий эд хөрөнгө тоологдсон байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 241 тоот тогтоолын дагуу 2015 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дууссан болон цаашид ашиглагдах боломжгүй эвдэрсэн 139 нэр төрлийн 113,324.4 мянган төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгийг өмч хамгаалах байнгын комисс акталж устган, балансаас хассан байна.

**4.2. БАРАА МАТЕРИАЛ**

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын бараа материал оны эхэнд 480,710.6 мянган төгрөгийн бараа материалтай, 784,207.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол жилийн эцэст 748,462.3 мянган төгрөгөөр хасагдаж 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 516,456.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий

бараа материал тоологдсон байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

№	Нэрс	Эхний үлдэгдэл	орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Тусгай зориулалтын материал	8,113.8	69,488.9	68,492.8	9,109.9
2	Аж ахуйн материал	66,531.3	38,013.7	66,428.1	38,116.9
3	Сэлбэг хэрэгсэл	480.0	80,406.7	80,886.7	0.00
4	Бичиг хэргийн материал	2,757.5	16,868.1	18,222.2	1,403.4
5	Барилгын засварын материал	21,676.6	193,236.6	195,107.1	19,806.0
6	Шатахуун		161,037.86	161,037.86	0.00
7	Хүнсний материал	1,478.86	157,470.59	157,828.84	1,120.6
8	Бусад хангамжийн материал	379,672.62	67,685.30	458.79	446,899.1
Нийт		480,710.7	784,207.7	748,462.3	516,456.0

### Тав. Илэрсэн зөрчил, дутагдлын талаар

- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын дарга О.Заяамандах нь өөрт олгогдсон эрх хэмжээг хэтрүүлж “Ландкрузер-200” маркийн 02-44 УНУ улсын дугаартай автомашины 100 км-т зарцуулах шатахууны үндсэн нормыг 35.1 литр болгон нэмэгдүүлж 2016 оны 1-8 дугаар сар болон 10 дугаар сард нийт 2479.2 литр шатахуун илүү зарцуулж 4,338.6 мянган төгрөгийн нэмэгдэл зардал гаргасан байна.

- 2016 оны 11,12 дугаар саруудын хөтлөгдвөл зохих АШБ-ийг бүрэн хөтөлж, хүнсний нэр төрлийн тайланг гаргаж, нягтлан бодогчоор тооцоо бодуулж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг зөрчсөн;

- Сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдэлгүйгээр тайлан гаргасан, агуулахаас ашиглалтад шилжсэн, ашиглаж байгаа, эдэлгээний хугацаа, норм дуусаагүй /техникийн хувийн хэрэгт бичээд/ сэлбэг хэрэгслийг бүртгэлд орлого авдаггүй, данс бүртгэлээс хасч, акталсан;

- Аудитын байгууллагаас өгсөн /2015 оны/ зөвлөмжийн хэрэгжилт 50.4 хувьтай байгаа бөгөөд эрх бүхий байгууллагуудаас удаа дараа хийсэн шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулж ажиллаагүй;

- Ажилтнуудын ажлын үр дүнг тодорхой дүгнээгүй хавтгайруулан шагнах замаар 83.0 сая төгрөгийг шагналт цалин хэлбэрээр олгосон байна. Ажилтнуудын ажил дүгнэх журмыг боловсруулан баталж мөрдөөгүй;

- АСЕМ-д зориулж БНХАУ-аас буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, ААНБ, иргэдэд ААН, хувь хүмүүст

худалдсан тавилгын төлөгдсөн төлбөрийг өглөгөөр бүртгэсэн ч, төлөгдөөгүй үлдэгдэл төлбөрийг авлагаар бүртгээгүй, санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл огт хөтлөөгүй, зөвхөн нярвын гар бичмэл тооцоогоор явж ирсэн, нягтлан бодогч нь эд хариуцагчийн тооцоо бодож акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”-ын 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэснийг зөрчсөн;

- Буцалтгүй тусламжийн хөрөнгийг үнэлж, борлуулах болон төрийн байгууллагуудад шилжүүлэх талаар албажуулсан тодорхой шийдвэр байхгүй, зөвхөн зочид буудлуудаас ирүүлсэн үнийн саналаар үнэлж шилжүүлсэн буюу худалдаж борлуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.4-д “Эд хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах заавар, журмыг Сангийн яам гаргана.”, Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.5-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь хандив, банкны зээл, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон эд хөрөнгө олж авбал энэ тухай Сангийн яаманд мэдэгдэж, уг хөрөнгийг бүртгэлд тусгана” гэсэн заалтыг зөрчсөн.

- Буцалтгүй тусламжаар нийлүүлсэн Орчуулгын тоног төхөөрөмжийг өмчийн харилцааг зохицуулах эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр түрээслүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн.

- ААН, хувь хүмүүст худалдсан буцалтгүй тусламжийн тавилга, эд хогшлын төлөгдсөн төлбөрийг өглөгөөр бүртгэсэн боловч, төлөгдөөгүй үлдэгдэл 589.2 сая төгрөгийн үлдэгдэл төлбөрийг авлагаар бүртгээгүй зөрчилд акт тогтоов.

- Худалдан авалтын 2016 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,310.0 мянган төгрөгийн програм хангамжыг худалдан авсан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэснийг зөрчсөн байна.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 241 тоот тогтоолын дагуу 2015 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дууссан болон цаашид ашиглагдах боломжгүй эвдэрсэн 139 нэр төрлийн 113,324.4 мянган төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгийн устгалын акт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2016 оны 131-р тушаалаар батлагдсан эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын холбогдох заалтыг зөрчсөн байна.

- Акталсан эд хөрөнгийн жагсаалтаас нийт 12,091.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг устгаагүй, дахин үнэлэлгүй, данс бүртгэлд тусгалгүйгээр хэрэглэж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 196 тушаалаар батлагдсан эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын холбогдох заалтыг зөрчсөн байна.

- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын харьяа Чин Ван Ханддоржийн өргөөний хажууд 20 тн-ын 2 ширхэг чингэлэг үндсэн хөрөнгөд бүртгэлгүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 196 тушаалаар батлагдсан эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын холбогдох заалтыг зөрчсөн байна.

- 95 цогцолборын балансын анхны өртөг 5,291,049,494.01 төгрөг хуримтлагдсан элэгдэл 1,648,739,573.15 төгрөг, 2016 онд нэмж байгуулсан элэгдэл 165,352,505.00 төгрөг байна. Энэ /цогцолбор/ хөрөнгийг тайланд онд хувьчилсан байхад элэгдэл байгуулж зардал нэмэгдүүлсэн. Дээрхи хөрөнгөнд элэгдэл байгуулсан хэмжээгээр /165,3 сая төгрөг/ зардал өсч ашгийн хэмжээ буурч, татвар ногдох орлого буруу тодорхойлогдон, баланс тайлан будлиантах нөхцлийг бүрдүүлсэн байна.

- Тус газрын ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Эрдэнэсүвд нь Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 258 дугаар тушаалаар батлагдсан Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журмыг зөрчин 2015 онд 1,652.7 мянган төгрөг, 2016 онд 1,809.2 мянган төгрөг, 2017 онд 1,083.5 мянган төгрөг, нийт 4,545.4 мянган төгрөгийг цалингийн нэмэгдэл болгон авсан зөрчил илэрлээ. /төлбөрийн акт тогтоосон/

### **Зургаа. Дүгнэлт:**

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын /статустай/-гаар өөрийн чиг үүрэг, дүрмийн дагуу үйл ажиллагаагаа



хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан зорилтот түвшинг ханган биелүүлж ажилласан байна.

2016 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журам, аргачлалыг баримтлан санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу хуулийн хугацаанд нь гаргаж, хөндлөнгийн аудитын "Бодит бүртгэл" аудит ХХК-иас "Зөрчилгүй" гэсэн санал дүгнэлттэйгээр холбогдох газарт тушаажээ.

"ДБУЭГ" ТӨҮГ нь 2016 онд 4,783.5 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж гүйцэтгэлээр 5,536.5 сая төгрөг болж 16.0 хувиар буюу 753.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч, орлогын өсөлттэй дүйцэхүйц хэмжээгээр зардал өссөн байна.

Цэвэр ашиг гүйцэтгэлээр 30.9 сая төгрөг болж, төлөвлөсөн хэмжээнээс 20.4 сая төгрөгөөр буюу 2,9 дахин давуулан биелүүлж, орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 0,01 мөнгөөр бууруулсан байна. Төрийн өмчийн ногдол ашигт 6,2 сая төгрөг төлж, төлөвлөгөөг 193.0 хувиар буюу 4,1 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Зардал 4,771.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч, гүйцэтгэлээр 5,504.8 сая төгрөг болж 733.0 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар хэтэрчээ.

Нийт 30 нэрийн зардлаас 10 төрлийн зардлыг 6,7-117,6 сая төгрөгөөр хэмнэж, 20 нэрийн зардлыг 1,0-373,2 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулжээ. Энэ байдлаас үзэхэд дээрхи шалтгаанаас гадна төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байгааг анхааралдаа авч ажиллах шаардлагатай болсон байна.

Төсвийн жилд тооцоо судалгаагүй хандаж, батлагдсан зардлыг хэтрүүлсэн, төлөвлөгөөгөө баримталж, холбогдох хууль журмыг мөрдөлгүй, зардал гаргасан, санхүүгийн сахилга, зардлын менежмент хангалтгүй байснаас зардлыг хэмнэж хямдруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарч, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Санхүүгийн шинжилгээ хийдэггүй, үр ашгийн үзүүлэлтүүдийг тооцож, өртөг зардлыг хямдруулах, үр ашгийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй урсгалаар явж ирсэн байна. Иймд төлөвлөлтийг сайжруулж, шинжилгээ судалгаа хийж дүгнэлт гарган удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй байгаа нь тус газарт эдийн засагч ажиллах шаардлагатай байна.

АСЕМ-д зориулж БНХАУ-аас буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл огт хөтлөөгүй, зөвхөн нярвын тооцоогоор явж ирсэн, нярав нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр хөрөнгө зарлагадсан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн тооцоо бодож акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт"-ын 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэснийг зөрчсөн байна.

Буцалтгүй тусламжийн хөрөнгүүдийн Өмчийн харилцааг зохицуулах эрх бүхий байгууллагаас үнэ тогтоох, эзэмшил харъялалыг тогтоогоогүй байхад аж ахуйн нэгж иргэд, байгууллагуудад худалдан борлуулсан, шилжүүлсэн, түрээслүүлсэн байна. Гэтэл энэ ажлыг дууссаны дараа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь 2017 оны 3, 4, 7 дугаар сардуудад Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газраас оруулсан саналын дагуу хөрөнгийн үнэлгээг зөвшөөрч, худалдах болон үнэ төлбөргүй шилжүүлэх шийдвэрийг нөхөн гаргасан байгаа нь төрийн өмч, эд хөрөнгийн харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий тус газраас энэ асуудлыг зохицуулж шийдвэрлэх талаар эхнээс нь хяналт тавьж зохицуулаагүй нь өмч хөрөнгө үнэгүйдэх, шамшигдах эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

#### **Долоо. Цаашид авах арга хэмжээний талаар**

- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, мэргэжлийн дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх;

- Агуулахаас ашиглалтад шилжсэн ашиглаж байгаа эдэлгээний хугацаа дуусаагүй, хэлбэр дүрс нь өөрчлөгддөггүй хөрөнгийг /техникийн хувийн хэрэгт бичээд/ данс бүртгэлээс хассан зөрчлийг арилган, орлогод авч бүртгэлд тусгах;

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хураангуй товч тодорхой болгох, онолын шинжтэй ерөнхий оршил хэсгүүдийг хасах, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгах, үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, элэгдлийн хувь хэмжээг тогтоож шийдвэр гаргах, элэгдлийн хувь хэмжээг тодорхой болгосны үндсэн дээр, ашиглагдаж байгаа сэлбэг, тоног төхөөрөмж, хөрөнгийг бүртгэлд яаж тусгахыг тодорхой болгох;

- Бизнес төлөвлөгөөг / дунд хугацааны/ шинээр боловсруулж баталж мөрдөж ажиллах;

- Аудитын болон эрх бүхий байгууллагуудаас удаа дараа хийсэн шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах;

- Тус байгууллага нь 2016 оноос төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болсонтой холбогдуулан тус газрын үйлчилгээний /суудлын автомашин, зоогийн болон бусад үйлчилгээний/ үнэ тарифыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг байсныг өөрчлөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон бусад холбогдох хуулийн дагуу зохицуулах;

- Буцалтгүй тусламжаар нийлүүлсэн Орчуулгын тоног төхөөрөмжийг Өмчийн харилцааг зохицуулах эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр түрээслүүлсэн асуудлыг шийдвэрлүүлэх;

- Ажилтнуудын ажил дүгнэх журмыг боловсруулан баталж мөрдөх, /нийтлэг үзүүлэлтээс гадна гүйцэтгэж буй ажил, албан тушаалын онцлогийг харгалзан ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой гаргасан журам боловсруулах/;

- Санхүүгийн тайланд эдийн засгийн шинжилгээ хийж дүгнэлт гарган, удирдлагыг мэдээллээр хангаж байхын зэрэгцээ, төлөвлөлтийг сайжруулах, зардлыг хямдруулах, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, орон тооны эдийн засагч ажиллуулах;

- Акталсан эд хөрөнгийн жагсаалтаас нийт 12,091.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг устгаагүй, дахин үнэлэлгүй, данс бүртгэлд тусгалгүйгээр ашиглаж байгаа зөрчлийг арилгах;

- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын харьяа Чин Ван Ханддоржийн өргөөний хажууд 20 тн-ын 2 ширхэг чингэлэг үндсэн хөрөнгөд бүртгэлгүй байх тул бүртгэлд тусгах;

- 95 цогцолборын балансын анхны өртөг 5,291,049,494.01 төгрөг, хуримтлагдсан элэгдэл 1,648,739,573.15 төгрөг, 2016 онд нэмж байгуулсан элэгдэл 165,352,505.00 төгрөг байна. Энэ /цогцолбор/ хөрөнгийг тайлант онд хувьчилсан байгаа тул элэгдэл байгуулж зардал нэмэгдүүлэх шаардлагагүй элэгдлийг буцааж залруулах;

- Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын дагуу автомашины 100 км-т зарцуулах шатахууныг спидометрийн заалтаар баталгаажуулж, жолоочийн тооцооны хуудас бөглүүлж байх;

- ААНБ, иргэдэд ААН, хувь хүмүүст худалдсан буцалтгүй тусламжийн тавилгын төлөгдөөгүй төлбөрийг дансанд авлагаар бүртгэн, үлдэгдэл 589.2 сая төгрөгийг бүрэн барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлэх;

- Холбогдох эрх зүйн актыг зөрчин олгосон цалингийн нэмэгдэл 4,545.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх;

Шалгалтын мөрөөр гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар төлөвлөгөө гарган, тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан биелэлтийг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2018 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэхийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын захирал /Ё.Нямжав/-д үүрэг болгож байна.

#### Шалгалтын тэмдэглэл

**Бичсэн:**  
САНГИЙН ЯАМНЫ СХШХ-ИЙН  
УЛСЫН АХПАХ БАЙЦААГЧ  
Д.ГЭРЭЛ  
Н.БАТБААТАР  
УЛСЫН БАЙЦААГЧ  
С.БАТТӨР  
СХШХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Б.ГАНТУЛГА

**Танилцсан:**  
ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ЗАХИРАЛ Е.НЯМЖАВ  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА С.СОЛОНГО  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Б.БОЛДБААТАР



## САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар: 16

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Дотоод аудитын хорооны 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг хэлэлцээд шийдвэрлэх хүрээнд:

Шалгалтаар илэрсэн зөрчилд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 593,748.9 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх 2 акт тогтоосныг хугацаанд нь барагдуулж ажиллахыг даалгасугай.

**Хоёр.** “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг засч арилгах, давтан гаргахгүй байх талаар арга хэмжээ авч, зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган, хяналт тавьж ажиллах, мөн дараах асуудлуудад анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

### **2.1. Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГазарт:**

- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, мэргэжлийн дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тодорхой болгох, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусган, үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, элэгдлийн хувь хэмжээг тогтоох шийдвэр гарган хэрэгжүүлэх;
- Бизнес төлөвлөгөөг /дунд хугацааны/ шинээр боловсруулан баталж, мөрдөж ажиллах;
- Тус байгууллага нь 2016 оноос төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болсонтой холбогдуулан үйлчилгээний /суудлын автомашин, зоогийн болон бусад үйлчилгээний/ үнэ тарифыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг байсныг өөрчлөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон бусад холбогдох хуулийн дагуу зохицуулах;

- Ажилтнуудын ажил дүгнэх журмыг боловсруулан, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхой тусган хэрэгжүүлэх;
- Санхүүгийн тайланд эдийн засгийн шинжилгээ хийж дүгнэлт гарган, удирдлагыг мэдээллээр хангаж байхын зэрэгцээ, төлөвлөлтийг сайжруулах, зардлыг хямдруулах, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч, орон тооны эдийн засагч ажиллуулах;
- Акталсан эд хөрөнгийн жагсаалтаас нийт 12,091.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг устгаагүй, дахин үнэлэлгүй, данс бүртгэлд тусгалгүйгээр ашиглаж байгаа зөрчлийг арилгах;
- Буцалтгүй тусламжаар нийлүүлсэн Орчуулгын тоног төхөөрөмжийг Өмчийн харилцааг зохицуулах эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр түрээслүүлсэн асуудлыг шийдвэрлүүлэх;
- Тайлант онд хувьчилсан 95 цогцолборын барилгад зардал нэмэгдүүлж элэгдэл байгуулсаныг буцаан залруулах;
- Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын дагуу автомашины шатахууны тооцоог бодох,
- Аж ахуйн нэгж, хувь хүмүүст худалдсан буцалтгүй тусламжийн тавилгын төлөгдөөгүй төлбөрийг дансанд авлагаар бүртгэн, үлдэгдэл 589.2 сая төгрөгийг бүрэн барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлэх;
- Холбогдох эрх зүйн актыг зөрчин олгосон цалингийн нэмэгдэл 4,545.4 мянган төгрөгийг холбогдох эздээр төлүүлэх;

## **2.2. Гадаад харилцааны яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт**

а/. БНХАУ-аас 2016 онд Ази Европын орнуудын дээд хэмжээний чуулга уулзалтад зориулж ирүүлсэн буцалтгүй тусламжийн хөрөнгийг нэгбүрчлэн жагсаалтаар гарган ирүүлэх;

б/. Монгол Улсын Их Хурлын тогтоолыг зөрчиж гаргасан Засгийн газрын тогтоолоор “Дипломат-95” цогцолбороос 2016 онд 80 айлын орон сууц хувьчилсаныг хууль, тогтоомжид нийцүүлэх;

## **2.3. Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт**

ДБҮЭГ-ын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар их хэмжээний зөрчил, дутагдал илэрсэн байхад тус газрын 2016 оны санхүүгийн



тайланд “Бодит бүртгэл аудит” ХХК аудит хийж “Зөрчилгүй” гэсэн санал дүгнэлт өгсөн асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах;

**Гурав.** Аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн үүргийг хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлт хангагдах хүртэл улирал тутам Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тайлагнахыг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” /ТӨҮГ/-ын удирдлагад, Гадаад харилцааны яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт өгөгдсөн үүргийн биелэлтийг 1 дүгээр улиралд багтаан ирүүлэхийг тус тус хариуцуулсугай.

**Дөрөв.** Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж Дотоод аудитын хороонд эргэн танилцуулахыг Санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД, ДОТООД АУДИТЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР